



БНМАУ

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН
ХҮРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

ТОГТООЛ

1990 оны 3
сарын 29 өдөр

дугаар 56.

Улаанбаатар

нэгдэн 1993 оны 4/22-д Засаг даргаар хэлэлцүүлж

Галууны аж ахуйн үйлд-
вэр байгуулах тухай

Орон нутгийн чанартай үйлдвэрлэлийг зохимон байгуулж ард түмний өргөн хэрэглээний барааны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, ажлын байр шинээр бий болгох зорилгоор Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. ХААХХҮЯ -ны харьяа Шувууны аж ахуй үйлдвэрлэлийн нэгдэл, Зармэлийн үйлдвэртэй тохиролцсон санал, техник-эдийн засгийн үндэслэлийг үндэслэн Улаанбаатар хотын Хөдөө аж ахуйг удирдах газрын харьяалалд галууны аж ахуйг хөгжүүлж бүтээгдэхүүнийг ашиглах, ноосон сүлжмэл эдлэл үйлдвэрлэх "Галууны аж ахуйн" -ийн ашиглалтын өмнөх захиргааг байгуулсугай.

2. Улаанбаатар хотын Галууны аж ахуйн үйлдвэр галууны ферм байгуулах 20,0 мянган амметр газрыг Туул хорооны нутаг дэвсгэрт олгохыг Архитектур төлөвлөлтийн газар /н. Жадамбаа/, Байгаль орчныг хамгаалах газар /н. Дагвадорж/, Туул хорооны АДХ-ын гүйцэтгэх захиргаа /н. Сатей/-нд тус нэгдлийн захиргаа, үйлдвэрлэлийн цехүүдэд зориулан УСАУТ-ын цэвэрлэх байгууламжийн ажилчдын 32 айлын орон сууц байсан барилгыг балансаас балансад шилжүүлэн өгөхийг хотын Ус сувгийн ашиглалтыг удирдах газар /н. Баасандорж/-т даалгасугай.

3. Дээрх орон сууцны барилгыг үйлдвэрлэлд зохицуулан засаж өөрчлөх зураг төсвийг 4 дүгээр сард багтаан хийх, Галууны фермд 1991-1992 онд баригдах байр, саравчны зураг төсвийг 1990 онд багтаан хийхийг Архитектур төлөвлөлтийн газар /н. Жадамбаа/-т, орчимд нь ногоон хамгаалалтын 100 метрээс доошгүй өргөн зурвас байгуулахыг Хот тохижуулах газар /н. Эрдэн-Очир/-т, эдгээр ажилд шаардагдах хөрөнгийг хотын хөрөнгө оруулалтаар олгохыг Төлөвлөгөө, эдийн засгийн хэлтэс /н. Бат/-т

тус тус үүрэг болгож, фермийн байр барих, цехийн барилга засварлах ажлын захиалагчаар тус үйлдвэрийн ашиглалтын өмнөх захиргааг баталсугай.

4. Галууны аж ахуйн үйлдвэрийн ажилчдад Октябрийн районы дэвсгэрийн ерөнхий боловсролын сургуулийн 8, 10 дугаар анги төгсөгчдөөс голлон элсүүлж ажиллуулахыг Хөдөлмөр зохицуулах товчоо /н.Далайбаатар/-нд даалгасугай.

5. Галууны аж ахуйн үйлдвэрийн хэрэгцээнд эхний хагас жилд багтаан дугуйт трактор нэгийг хадлангийн тоног төхөөрөмж, чиргүүлийн хамт олж өгөхийг Хотын Хөдөө аж ахуйг удирдах газар /н.Мижиддорж/-т, УАЗ-469 маркийн нэг машиныг шилжүүлж өгөхийг Хотын тээврийг удирдах газар /н.Дашварэн/-т үүрэг болгосугай.

6. Галуу үржүүлэх, түүхий эд, ноолуур, элэг, мах, арьсыг ашиглаж байгаа туршлагыг судлуулахаар ЗХУ, БНХАУ-д энэ оны II улиралд тус бүр 2 хүн явуулахыг Зохион зааварлах хэлтсийн гадаад харилцааны тасаг /н.Туяа/-т, дээрх орны туршлагыг нарийн судалж, өөрийн орны нөхцөлд нэвтрүүлэх, шаардагдах тоног төхөөрөмж, материал түүхий эд, үржлийн өндөг, дэгдээхэй худалдаж авах, өөрийн бүтээгдэхүүн, түүхий эдээ борлуулах талаар гадаад орны холбогдох байгууллагуудтай шууд харилцаа тогтоох асуудлыг боловсруулж шийдвэрлүүлэхийг Галууны аж ахуйн үйлдвэрийн ашиглалтын өмнөх захиргаа /н.Пүрэвдорж/-д даалгасугай.

7. Улаанбаатар хотын Галууны аж ахуйн үйлдвэрийн ашиглалтын өмнөх захиргааны зардал 246,0 мянган төгрөгийг орлогын төлөвлөгөө давуулсны шагналын хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүүгийн хэлтэс /н.Гонгор/-т зөвшөөрсүгэй.

8. 1991 оноос галууны өдөн хувцас оёх, галууны арьс боловсруулж, төрөл бүрийн өргөн хэрэглээний бүтээгдэхүүн хийх, галууны мах боловсруулах цехүүд байгуулах зэргээр үйлдвэрлэлийг өргөжүүлж ажиллахыг Галууны аж ахуйн үйлдвэрлэлийн ашиглалтын өмнөх захиргаа /н.Пүрэвдорж/-д үүрэг болгосугай.

9. Галууны аж ахуйн үйлдвэрийг байгуулах, цаашид хэвийн ажиллагааг хангах асуудлаар Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаа, Хөдөө аж ахуйн хөнгөн хүнсний үйлдвэрийн яамны харьяа Шувууны аж ахуйн үйлдвэрлэлийн нэгдэл, Ээрмэлийн үйлдвэрийн харилцан хүлээх үүргийн талаар урт хугацааны гэрээ байгуулахыг хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны нэгдүгээр орлогч даргад зөвшөөрч, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг үүрэг болгосугай.



УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА

[Signature]

Д.ЭНЭВИШ

ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИЧИЙН
ДАРГА

[Signature]

Д.АЛГИА